



## ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛ

**ЗОРИЛГО:** Орон нутгийн нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах төсөл, хөтөлбөрийг оновчтой сонгох, үр өгөөжийг дээшлүүлэх, орон нутгийн иргэдтэй нээлттэй ил тод харилцааг өрнүүлэн хөгжүүлэхэд, мөн компанийн нийгмийн хариуцлагатай үйл ажиллагааг болон нутгийн иргэд уруу чиглэсэн бусад арга хэмжээг ил тод байлгахад хамтран ажиллахад оршино.

**ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:** Хамтын ажиллагааны зөвлөл нь орон нутгийн төр захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, малчид, "Бадрах Энержи" ХХК-ийн төлөөлөл бүхий 15 гишүүнтэй. Баг бүрээс, багийн иргэдийн нийтийн хурлаар ХАЗ-ийн гишүүдийг сонгодог. "Бадрах Энержи" ХХК-ийг төлөөлж Орон нутгийн харилцааны багийнхан хурал бүрт оролцож, ажилладаг. Зөвлөлийн хурлыг орон нутгийн төлөөллөөс сонгогдсон дарга удирдан явуулдаг.

Зөвлөлийн хурал нь ажиглагчаар оролцох хүсэлтэй иргэн бүрт нээлттэй явагддаг онцлогтой.

Хамтын ажиллагааны зөвлөлүүдийг 2013 онд байгуулан түүнээс хойш нийт 45 удаа зөвлөлийн хурлыг зохион байгууллаа.

**ҮЙЛ АЖИЛЛАГАА:** “Бадрах Энержи” ХХК нь үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг Дорноговь аймгийн Улаанбадрах сум ба Сайншанд сумын Зүүнбаян багтай хамтран Хамтын ажиллагааны зөвлөлүүдийг 2013 онд байгуулан түүнээс хойш нийт 45 удаа зөвлөлийн хурлыг зохион байгууллаа. Зөвлөл улиралд нэг удаа хуралддаг. Зөвлөлийн гишүүдийн урьдчилан гаргасан хэлэлцэх сэдвийн дагуу компани

мэдээлэл өгдөг ба тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бусад судалгааны ажлын тайлан зэргийг танилцуулан, хэлэлцүүлдэг. Нөгөө талаас орон нутгийн гишүүд, иргэдийн төлөөлөл компанийн танилцуулсан сэдэвтэй холбоотой аливаа асуулт, санал, хүсэлт зэрэгтээ хариу авч, харилцан санаа бодлоо солилцож чаддагаараа уг Зөвлөл нь компани ба иргэдийн хоорондын харилцааны гол гүүр болдог.



#### **УЛААНБАДРАХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ – 4**

2018 оны 12 дугаар сарын 25-нд Дулаан уулын анги дээр болсон ХАЗ-ийн хамтарсан хуралдааны сэдвүүд:

- 2018 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн тайлан
- Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хийгдсэн ажил
- 2019 оны төлөвлөгөө.

#### **ОРОЛЦОГЧИД:**

Зөвлөлийн гишүүн - 28, ажиглагч- 3.



Төслийн явцын тухай мэдээллийг бидний Фэйсбүүк хуудаснаас авна уу.  
<https://www.facebook.com/badrakhenergy>